



ОЮУНЫ ӨМЧИЙН ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2020 оны 05 сарын 05 өдөр

Дугаар А/91

Улаанбаатар хот

Зохиогчийн эрхийн гэрчилгээнд өөрчлөлт
оруулж гэрчилгээг дахин олгох тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4 дэх хэсэг, Зохиогчийн эрх болон түүнд хамаарах эрхийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1.5 дахь заалт болон бүтээл өмчлөгч “Ай Ло Инновэитив” ХХК-ийн өргөдлийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Лигал сорс” ХХК нь 2020 оны 04 сард нэрээ “Ай Ло Инновэитив” ХХК өөрчилсөн тул тус компанийн эзэмшдэг Оюуны өмчийн газрын даргын 2019 оны А/130 дугаар тушаалаар олгогдсон “ILAW.MN” нэртэй улсын бүртгэлийн 10828 дугаартай гэрчилгээ эзэмшигчийн нэрийг “Ай Ло Инновэитив” ХХК-ийн нэр дээр өөрчилж олгосугай.

2. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Зохиогчийн эрхийн хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч /Д.Бат-Эрдэнэ/-д үүрэг болгосугай.

ДАРГА

Ц.АЗБАЯР